



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.31 № 3/587
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУО, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



“УБЦТС” ТӨХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын САГ-ын дарга,
Тэргүүлэх аудитор:
Ц. Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885

Ахлах аудитор: Д.Ганбилэг
Утас: 260512

ТАБ-ын хаяг:
Үндэсний аудитын газар
Байршил: Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын IV байр
Цахим хуудас: www.audit.mn



Аудитын партнер : Н.Эрдэнэцог
Утас: 976-11-70110744, 99030092
И-мэйл: erdenetsog@ulaanbaatar-audit.mn

Аудитын менежер: Б. Дэлгэрмаа
Утас: 976-11-329430, 99005373
И-мэйл: delgermaa@ulaanbaatar-audit.mn

Хаяг: Чингэлтэй дүүрэг, .
5-р хороо, Их тойруу, Маргад центр байрны
4-р давхар

АУДИТЫН ТАЙЛАН

- 1: Агуулга
- 2: Аудитын гэрчилгээ
- 3: Менежментийн захидал
- 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан
- 5: Нэмэлт тодруулгууд

АГУУЛГА

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:	1
Компанийн хууль, эрх зүйн орчин:	1
Компанийн зорилго, үйл ажиллагаа:	2
Материаллаг түвшин:	3
Дотоод хяналт:	4
Бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:	5
Шилэн дансны мэдээлэл	6
Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:	6
Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:	7
Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:	8
Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:	12
Анхаарал татахуйц бусад чухал асуудал:	12
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:	13
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	13
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:	14
Аудитын санал дүгнэлт	14
Менежментийн захидал	16
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	19
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	20
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	21
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	22

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын “Төрийн аудитын тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, “Төсвийн тухай” хуулийн 8.9.8 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2013 оны 158 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх журам”-ын 2.7 дугаар зүйлд заасан заалтуудыг үндэслэл болгон “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2017/1/СТА-ТӨҮГ/ аудит хийлээ.

Бид энэхүү аудитыг “Төрийн аудитын тухай” хууль, “Аудитын тухай” хууль, Аудитын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам” мөн Ерөнхий аудиторын 2013 оны 158 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх журам”, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн аудитын горим, арга, аргачлал болон бусад холбогдох дүрэм, журамд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Энэхүү аудитын ажлын үндсэн зорилго бол “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлангууд нь материаллаг зүйлсийнхээ хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Монгол улсын холбогдох хууль тогтоомж, Сангийн яам, Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан заавар, журмын дагуу илэрхийлэгдсэн гэдэгт аудиторын дүгнэлт гаргаж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх явдал юм.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны завсрын аудитыг 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 11 дүгээр сарын 24-ний хооронд болон жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талбарын аудитыг 2017 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс 2017 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Компанийн хууль, эрх зүйн орчин:

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Компанийн тухай”, “Эрчим хүчний тухай”, “Шилэн дансны тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Нягтлан бодох бүртгэл, нийгмийн даатгал, татварын багц хуулиуд, “УБЦТС ТӨХК

хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”, “Тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн дүрэм, хамтын гэрээ зэрэг хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн зорилго, үйл ажиллагаа:

“УБЦШСГ” (Улаанбаатар цахилгаан шугам сүлжээний газар) нь Монгол Улсын Засгийн газрын 2001 оны долдугаар сарын 9-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” хувьцаат компани болж өөрчлөгдсөн байна. Тус ТӨХК нь 2005 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж 9012001012 гэсэн улсын бүртгэлийн дугаар авсан байна.

“УБЦТС” ТӨХК нь Улаанбаатар хотын найман дүүрэг, Төв аймгийн 16 сумын нутаг дэвсгэрийн 307 мянга гаруй хэрэглэгч буюу Монгол Улсын нийт хүн амын 50 шахам хувийг цахилгаан эрчим хүчээр хангах үйл ажиллагаа эрхэлдгээрээ эрчим хүчний дотоодын зах зээлд томоохон байр суурийг эзэлдэг байна.

Компани нь дараах тусгай зөвшөөрлийг эзэмшин үйл ажиллагаагаа явуулж байна:

- Цахилгаан эрчим хүч түгээх
- Цахилгаан эрчим хүчээр зохицуулалттай хангах
- Цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөний угсралт, засвар, туршилт тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх (0.4-35 кВ)
- Цахилгаан шугам сүлжээний зураг төсөл боловсруулах (35 кВ хүртэл)
- Монгол Улсад зөвшөөрөгдсөн загварын цахилгаан эрчим хүчний 1 ба 3 фазын механик, электрон, импульсийн тоолуур гүйдлийн трансформатор засварлах, суурилуулах, худалдах
- 35/10/6/0.4 кВ-ын хүчдэлийн хуваарилах байгууламж, дэд өртөө, шугам тоноглолын ашиглалтын засвар үйлчилгээний инженер техникийн ажилтан, монтёрын мэргэжил олгох, дээшлүүлэх давтан сургалт

“УБЦТС” ТӨХК нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 15.2-д “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог”, мөн хуулийн 16.4-д “Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулдаг” гэсэн хуулийн заалтад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг.

“Компанийн тухай” хууль, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу ТӨХ-ны хуралдаанаас тогтоол гаргаж компанийн тухайн оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батладаг байна. Үүний дагуу тухайн оны бизнес төлөвлөгөөг баталж, биелэлтийн явцад хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгодог байна. Мөн эдийн засгийн үндсэн заасны дагуу ТӨХ-ны хуралдаанаас тогтоол гаргаж компанийн тухайн оны эдийн засгийн хямралын эсрэг арга хэмжээ авахыг Гүйцэтгэх захиралд даалгадаг байна.

Компанийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар компанийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд компанийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн компанийн зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 46-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг “Балхана аудит” ХХК шинэчлэн боловсруулж, бодлогын баримт бичгийг батлуулан тус компанид мөрдөж байна. Түүнчлэн “Улаанбаатар аудит корпораци” ХХК компанийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт боловсруулж, Гүйцэтгэх захирлын 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/82 тоот тушаалаар батлан мөрдөж байна.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг НББ-ийн “Интер Актив Ай Би Ай” ХХК-ийн “Диамонд-5” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг түвшин:

Материаллаг байдлын түвшинг 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт зардал (ББӨ, ЕУЗ, борлуулалт, маркетинг)-ын 1 хувиар тооцон 2,811,185.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

Нийт зардлын дүнгээс материаллаг түвшинг сонгон авсан шалтгаан нь тухайн компанийн тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзлээ.

Төлөвлөлт болон гүйцэтгэлийн үеийг 2016 оны 11 дүгээр сард завсрын аудитаар, гүйцэтгэлийн үеийг жилийн эцсийн аудитаар үргэлжлүүлэн 2017 оны 2, 3 дугаар саруудад хийж гүйцэтгэсэн ба материаллаг түвшинг нийт 2,811,185.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

Дотоод хяналт:

Бид компанийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлт болон аудитын гүйцэтгэлийн ажлын үед дахин хянаж үзээд, дараах зүйлд үндэслэн дотоод хяналт хэвийн байна гэж үзлээ. Үүнд:

1. Эрчим хүчний яамны Дотоод аудитын хэлтсээс Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан журмын дагуу шилэн дансыг хөтөлж, холбогдох 7 төрлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж байгаа эсэх талаар шалгалт хийж, Шилэн дансны хуулийн хэрэгжилт **Зөрчилгүй** үнэлгээ өгсөн байна.

2. Тайлант үед тус компанийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой Дотоод аудитын хэлтэс шинээр байгуулагдсан ба 2016 оны 11 дүгээр сараас эхлэн хэлтсийн дарга-1, дотоод аудитын нягтлан бодогч-3, нийт 4 орон тоотой ажиллаж байна. Тус хэлтсийн дотоод аудитор, нягтлан бодогчид компанийн Гүйцэтгэх захирлын 2013 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/75 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн дотоод аудитын журам"-ын дагуу 2016 онд санхүүгийн чиглэлээр 10 хяналт шалгалт, цаг үеийн болон Гүйцэтгэх захирлын удирдамжийн дагуу 13 төрлийн буюу давхардсан тоогоор 27 гэнэтийн хяналт шалгалт болон дүгнэлтүүдийг гаргаж, бүтээлч ажлын хүрээнд 3 ажил хийж, 2 албан даалгавар өгч, 9 албан тушаалтанд арга хэмжээ авч, 13,741.5 мянган төгрөгийн акт бичиж барагдуулсан талаар дотоод аудитын хэлтийн ажлын тайландаа тусгасан байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар компанийн Захирлын зөвлөлийн хурлаар оруулж, хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж холбогдох арга хэмжээг авч, уг шийдвэрт үндэслэн шалгалтад хамрагдсан нэгжүүдэд албан даалгавар, зөвлөмж өгч ажилладаг байна. Мөн нийтлэг гарсан алдаа дутагдлаар сургалт явуулдаг байна.

Компанийн Мэдээлэл технологийн хэлтсийн IT инженерүүд байгууллагын зорилго, зорилтуудыг хангахад ямар эрсдэлүүд гарч болохыг тодорхойлох, үнэлэх, санхүүгийн үйл ажиллагаанд учирч буй, цаашид учирч болзошгүй эрсдэлүүдийг үйл ажиллагааны бүх түвшинд тодорхойлон үнэлж, холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авахад зориулагдсан "Эрсдэлийн программ"-ыг зохиосон байна. Уг программыг 2015 оны 5 дугаар сараас туршиж, 8 дугаар сараас ашиглаж эхэлсэн байна.

Эрсдэлийн программыг компанийн хэмжээний бүх бүртгэл санхүүгийн ажилтнууд ашиглах ба "Санхүүгийн үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ хийх журам"-ыг мөрдөж ажиллана.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 6 дугаар сарын 08-ний өдрийн 2016/16 тоот "Аудитын хороо шинэчлэн батлах тухай" тогтоолын дагуу Дотоод аудитын хороог дарга, 2 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан ба тус компанийн дотоод хяналтын нягтлан бодогч нартай байнга холбоотой ажиллаж, ажилтай нь танилцаж үүрэг даалгавар өгдөг байна.

Аудитын хороо нь жил бүр гүйцэтгэсэн ажлын тайлангаа бэлтгэж, ТУЗ-ийн ажлын тайланд нэгтгүүлдэг байна. Харин 2016 оны аудитын хорооны тайлан нь аудитын явцад хараахан гараагүй байсан болно.

Аудитын хороо нь 2016 онд дараахи ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна:

- 2015-2016 онд Аудитын хорооны гүйцэтгэх ажлын төлөвлөгөө батлан түүний дагуу ажиллаж байна.
- Компанийн 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан. 2016 оны тайлан баланс гарсны дараа санхүүгийн тайланд дүгнэлт хийнэ.
- Хараат бус Аудитын 2015 оны санхүүгийн тайлангийн дүгнэлт, зөвлөмжтэй танилцах, зөвшилцөх ажил хийсэн.
- Компанийн 2015 оны 1,2,3,4 дүгээр улирлын болон 2016 оны 1,2,3 дугаар улирлын санхүүгийн тайлантай танилцаж зөвлөгөө өгч ажилласан.
- Хараат бус аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар гүйцэтгэх удирдлагад зөвлөмж өгсөн.
- 2016, 2017 онуудын Зорилтот түвшний үзүүлэлтүүдтэй нягтлан танилцаж тодорхой санал, зөвлөмж өгсөн.
- Компанийн дотоод хяналтын албаны ажилтай танилцаж, санал хүсэлтийн сонсож, зөвлөгөө өгсөн.
- Найдваргүй авлага данснаас хасах болон хөрөнгө актлах устгах акт баримтуудтай танилцаж зөвлөгөө өгсөн.

Бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Тус компани нь 2016 оны бизнес төлөвлөгөөгөө Компанийн хувь нийлүүлэгчдийн 2016 оны 01 сарын 25-ны өдрийн 01 тоот тогтоолоор батлуулан ажилласан байна.

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны зөвхөн цахилгааны орлогын гүйцэтгэл 255,299,379.1 мянган төгрөг байгаа ба төлөвлөгөөт орлого 99.5%-иар биелсэн байна. Орлогын төлөвлөгөө зорилтот түвшинд хараахан хүрээгүй ч өмнөх онуудтай харьцуулахад өсөлттэй байна.

ЦЭХ-ийн борлуулалтын орлого 282,350,700.0 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 7,932,300.0 мянган төгрөгийг олохоор төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр ЦЭХ-ийн орлогын төлөвлөгөө 0.2 хувиар буюу 679,600.0 мянган төгрөгөөр, үндсэн бус үйл ажиллагааны орлого 16.9 хувиар буюу 1,339,100.0 мянган төгрөгөөр тасарсан боловч 2015 онтой зэрэгцүүлбэл, ЦЭХ-ийн борлуулалтын орлого 10.3 хувиар буюу 26,371,700.0 мянган төгрөгөөр илүү, үндсэн бус үйл ажиллагааны орлого 11 хувиар буюу 811,700.0 мянган төгрөгөөр доогуур байна. ЦДҮС ТӨХК-иас 2016 онд 2,574,400.0 мянган кВтц эрчим хүч худалдан авахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 2 хувиар доогуур 2,522,000.0 мянган кВт.ц эрчим хүч худалдан авсан байна. Үүнийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулбал 1.63 хувиар буюу 40,300.0 мянган кВтц-аар илүү байна.

Тайлант хугацаанд цахилгаан эрчим хүчний нийт алдагдал 17.00 хувь буюу 437,700.0 мянган кВтц байхаар төлөвлөсөн, гүйцэтгэлээр 15.91 хувь буюу 401,200.0 мянган кВтц ЦЭХ болж алдагдлын төлөвлөгөөг 1.09 пунктээр буюу 36,500.0 мянган кВтц ЦЭХ-ээр бууруулсан байна.

Компанийн борлуулалтын орлого цуглуулалт, авлагын үлдэгдэл буурахгүй байгаа нь дараах хүчин зүйлээс шалтгаалж байна. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн хэрэглэгчид санхүүгийн хувьд хүнд байдалд байгаа нь шууд нөлөөлж байна.
- Гэр хороолол газар нутгийн ихээхэн хэсэгт тэлж байгаа боловч түүнийг дагаж банкны салбарын үйлчилгээ тэлэхгүй, алдагдалтай гэдэг шалтгаанаар салбарууд татан буулгаж байна.
- Гэр хорооллын тэлэлт болон хэрэглэгчийн цэгийн тооны өсөлт нь авлага барагдуулагч нарын ачааллыг нэмэгдүүлж, авлага барагдуулалтанд сөргөөр нөлөөлж байна.
- Орлогын төлөвлөгөө тасарсан нь эдийн засгийн хүнд байдал, цаг агаарын дулаарал, цахилгааны үнийн урамшууллыг тооцохгүй болсон зэргээс цахилгаан хэрэглэгчдийн хэрэглээ буурсан байна.

Шилэн дансны мэдээлэл

Тус компани нь Монгол Улсын “Шилэн дансны тухай” хууль 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр батлагдсанаас хойш хэрэгжүүлэн өөрийн вэб хуудсанд “Шилэн данс”-ны цэсийг оруулсан байна.

“Шилэн дансны хууль” болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тус компанийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/157 дугаар тушаалаар “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн “Шилэн дансны тухай” хуулийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг баталж, уг хуулийг 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж эхэлсэн байна.

Мөн мэдээллийн эх бэлтгэх, хариуцах албан тушаалтан, ажилтны ажлын байрны тодорхойлолтод ажил, үүргийг тодорхой тусгасан байна.

Журмын хэрэгжилтэд Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны албаны Дотоод аудитын нягтлан бодогчид хяналт тавьж ажиллаж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 48 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 46 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг дурьдвал:

- 2015 онд элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй, 15,915,531.8 мянган төгрөгөөр дахин үнэлүүлсэн үндсэн хөрөнгөнд тайлант хугацаанд татварын зорилгоор 1,602,593.0 мянган төгрөгийн элэгдэл тооцож, албан татвар ногдох орлогоос хасч тайлагнасан
- Хувь хүнд олгосон орлогоос Хувь хүний орлогын албан татвар суутгаж, төсөвт шилжүүлээгүй,
- Нягтлан бодох бүртгэлийг аккрузль сууриар бүртгээгүй, урьдчилж төлсөн даатгалын болон сургалтын зардлыг шууд зардалд тусгаж, тайлагнасан,
- Бараа материалын шинж чанартай хуурцаг, ном зэрэг бараа бүтээгдэхүүнүүдийг бараа материалын орлогод бүртгэхгүйгээр шууд зардалд бүртгэж, тайлагнасан

зэрэг нь санхүүгийн тайлангийн аккрэль суурь, оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Санхүүгийн тайлангийн тодруулга нь Сангийн яамнаас баталсан яамнаас “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар”-т нийцэхгүй байна.
- Өр төлбөрийг буруу ангилж бүртгэсэн.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлыг татвар ногдох орлогоос хасч тайлагнасан
- Зээлийн хүүгийн авлагыг хуримтлуулж бүртгээгүй.
- Аудитын үйлчилгээний зардлыг илүү тайлагнасан зэрэг зөрчлүүд илэрсэн.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал/тооцоо, өглөг, борлуулалтын орлого, өмч, дахин үнэлгээ, гадаад, дотоод албан томилолт, цалин, сургалт семинар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант хугацаанд "Компанийн эзэмшигчдийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэх тухай" Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолын дагуу эзэмшигчдийн өмчийн бусад хэсгээс төрийн өмчийг 61,169,019.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Тайланд хугацаанд Компани нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол, шийдвэрээр улсын төсөв, хөрөнгө оруулалтаар баригдсан 14,930,330.4 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдсан 1,309,970.6 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, мөн хувь иргэн, албан байгууллагаас 8,058,530.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан. Түүнчлэн Төр засгийн үйлчилгээг эрхлэх газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 582,540.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж авсан байна.

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2,522,016,912.0 кВт цаг эрчим хүчийг дунджаар 84.44 төгрөгөөр буюу нийт 212,961,794.4 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Компани нь 2016 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт орсон өөрчлөлтийн дагуу насжилт өндөртэй, хуучирч хоцрогдсон, ашиглалт багатай бараа материалд нийт 1,088,236.4 мянган төгрөгийн бараа материалын хасагдуулга байгуулж, цэвэр боломжит үнэ цэнээр тайлагнаж байна. Үүнд: 5 жилээс дээш насжилттай бараа материалд 100%-иар, 3-5 жилийн насжилттай бараа материалд 3%-иар бараа материалын нөөц байгуулдаг байна. Харин 1- 2 жил хүртэл насжилттай бараа материалд нөөц байгуулдаггүй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 247 тоот тогтоол, Гүйцэтгэх захирлын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/154 тоот тушаалаар 2,025,208.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Компани нь 2016 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт орсон өөрчлөлтийн дагуу цахилгааны борлуулалтын орлогын авлагын насжилтанд үндэслэн 3,617,747.4 мянган төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулсан байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2015 онд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй, дахин үнэлүүлсэн үндсэн хөрөнгөнд татварын зорилгоор элэгдэл тооцож, татвар ногдох орлогоос хассан байна.

Компани нь 2015 онд элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй хөрөнгийг 15,915,531.8 мянган төгрөгөөр дахин үнэлүүлсэн. Тайлант 2016 онд компани нь уг дахин үнэлүүлсэн үндсэн хөрөнгөнд татварын зорилгоор 1,602,593.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, "Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан"-д тайлагнасан байна. Уг зөрүүгийн тайлангийн түр зөрүүгийн хасагдуулах утга хэсэгт дахин үнэлсэн хөрөнгийн элэгдлийг татварын зорилгоор тайлагнасан нь орлогын албан татварын өглөгийг 400,648.3 мянган төгрөгөөр, орлогын албан татварын зардлыг 240,389.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, харин хойшлогдсон татварын өр төлбөрийг 160,259.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх нөлөө үзүүлсэн байна.

Шийдвэрлэсэн:

“Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль” болон “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-гийн журмын дагуу зөвлөмж өгсөн ба цаашид уг журмыг мөрдөж, хэрэгжүүлж ажиллах талаар удирдлагад хүргэх захидлаар зөвлөмж өгсөн.

Нягтлан бодох бүртгэлийг аккрузль сууриар бүртгээгүй талаар

Компани нь тайлант үед “Бодь даатгал” ХХК-тай 217/2016 тоот тээврийн хэрэгсэл, жолоочийн албан журмын даатгалын 57,510.6 мянган төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ, “ХААН даатгал” ХХК-тай ажиллагсдын гэнэтийн ослын даатгалын 246/2016 тоот, 62,220.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий даатгалын гэрээнүүдийг тус тус хийж, төлбөрийг шилжүүлж, зардлаар тайлагнасан байна.

Уг даатгалын гэрээнүүд нь 2016.09.01-нээс 2017.08.31 өдрийн хугацааг хамарсан боловч Компани шууд зардалд бүртгэсэн байгаа нь нягтлан бодох бүртгэлийн аккрузль сууриар мөрдөх зарчмыг зөрчсөн байна. Түүнчлэн 21,000.0 мянган төгрөгийн гадаад сургалтын урьдчилж төлсөн зардлыг шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Эдгээр гүйлгээнүүдийг нягтлан бодох бүртгэлийн аккрузль сууриар бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн суурь”-ийн 5.1 Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузль сууриар хөтөлнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

2016 оны завсрын аудитаар уг зөрчлийн талаар асуудлын бүртгэлээр залруулах талаар зөвлөмж өгсөн ба Компани нь 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх тайландаа залруулга хийж, 2017 онд ногдох дүнгээр урьдчилж төлсөн зардлаар тайлагнасан.

ААНОАТ-ын тухай хуулиар хасагдахгүй зардлыг татвар ногдох орлогоос хасч тайлагнасан талаар

Компани нь тайлант үед мэргэжлийн бус сонин, сэтгүүлийн зардал болох нийт 2,037.5 мянган төгрөгийн дүнтэй зардлыг татвар ногдох орлогоос хасч тайлагнасан байна. Уг зөрчил нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйл “Албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд хамрагдахгүй учир “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-гийн журмын дагуу хасагдахгүй зардалд тайлагнах,

Шийдвэрлэсэн:

2016 оны завсрын аудитаар “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-гийн журам мөрдөж, хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгсөн ба Компани уг хасагдахгүй зардлыг “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-д залруулж тайлагнасан.

Үндсэн хөрөнгийн товчоо тайлангийн дүн, санхүүгийн тайлангийн тодруулга, гүйлгээ балансын дүнгээс зөрүүтэй байгаа талаар

Компанийн үндсэн хөрөнгийн санхүүгийн тайлангийн дүн, гүйлгээ балансын дүнтэй тохирч байгаа боловч үндсэн хөрөнгийн товчоо тайлангийн өртгийн эхний үлдэгдлийн дүн нь гүйлгээ баланс болон санхүүгийн тайлангийн тодруулгын дүнгээс 100.0 мянган төгрөгөөр илүү, эцсийн үлдэгдэл нь 404,155.8 мянган төгрөгөөр дутуу байна. Харин үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн товчоо тайлангийн эхний үлдэгдлийн дүн нь 409.9 мянган төгрөгөөр илүү, эцсийн үлдэгдэл нь 7,266.6 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн:

Компани нь аудитын зөвлөмжийн дагуу санхүүгийн программын компаниар тохируулга хийлгэж, залруулсан.

Үндсэн хөрөнгийн санхүүгийн зорилгоорх элэгдлийн тооцоолол ЭХЗ Хорооны журамтай нийцэхгүй байна.

Компанийн зарим үндсэн хөрөнгийн санхүүгийн зорилгоорх элэгдлийн тооцоолол нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 53 дугаар

тогтоол, Гүйцэтгэх захирлын 2016 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/61 тоот "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох жил, элэгдлийн хувь шинэчлэн батлах тухай" тушаалд заасан хугацааг баримтлаагүй байна.

Шийдвэрлэсэн:

Цаашид анхаарч ажиллах талаар асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн.

Хувь хүнд олгосон орлогоос ХХОАТ суутгаж, төсөвт шилжүүлээгүй талаар

Тайлант хугацаанд Компани нь иргэн Батхишигээс 5,800.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий хуурцаг худалдаж авсан байх ба уг хувь хүнд шилжүүлсэн орлогоос хувь хүний орлогын албан татвар суутгаж, төсөвт шилжүүлээгүй байна. Уг зөрчил нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйл. **Албан татвар ногдуулах, төсөвт төлөх** зүйлийн 26.1.1 Энэ хуулийн 11 дүгээр зүйл, 12.2, 13.1.2-13.1.4, 15.1-д заасан орлогын дүнд мөн хуулийн 23.1-д заасан хувиар, 14.1.1-д заасан орлогын дүнд 23.2.1-д заасан хувиар, 8.1.6, 8.1.7-д заасан орлогын дүнд 23.2.2-т заасан хувиар, 8.1.8-д заасан орлогын дүнд 23.2.3-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх; заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дээрх заалтыг мөрдөж ажиллах талаар асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн.

Бараа материалын шинж чанартай бэлэг, дурсгалын зүйлсийг бараа материалын орлогод бүртгэхгүй шууд зардлаар тайлагнасан талаар

Компани нь тайлант үед 8,010.0 мянган төгрөгийн ном, 5,800.0 мянган төгрөгийн хуурцаг худалдан авсан байх ба уг бараа материалын орлогод авахгүйгээр шууд зардалд бичсэн байна. Эдгээр бараа материалаас зарим бараа материал нь тайлант үеийн эцсээр зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна. Уг зөрчил нь Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг дэх бараа материалын бүртгэлийн бодлоготой нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн:

Компанийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн дагуу бараа материалын орлогод бүртгэж, тайлагнах талаар асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн.

Өр төлбөрийг буруу ангилж, бүртгэсэн талаар

Зүүн түгээх төв нь шинэ холболтоор үнэгүй хүлээж авсан хөрөнгийг бүртгэхдээ өглөгийн дансны буруу ангиллыг сонгосноос урт хугацаат зээлийн төлбөрийн дансанд бүртгэж, тайлагнаснаас уг дансны үлдэгдлийг 4,015.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Уг өглөг нь хойшлогдсон орлогын дансанд бүртгэгдэх ёстой. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, байгууллагын НББ-ийн бичиг баримтын дагуу өглөгийн дансыг зөв ангилан бүртгэх

Шийдвэрлэсэн:

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, байгууллагын НББ-ийн бичиг баримтын дагуу өглөгийн дансыг зөв ангилан бүртгэх талаар асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба Компани жилийн эцсийн тайланд залруулга хийж тайлагнасан.

Санхүүгийн тайлангийн толилуулга Сангийн яамнаас баталсан Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар нийцэхгүй байгаа талаар

Компани нь Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд авсан нийт 693,517.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК болон “Дулааны 3-р цахилгаан станц”-д харъяаллын дагуу шилжүүлсэн ба уг гүйлгээг хөрөнгө оруулалтаар бүртгэлд тусгасан байна. Шилжүүлсэн хөрөнгийн дүнгээр зээлийн гэрээ хийсэн байгаа нь хөрөнгө оруулалтын тодорхойлолтод нийцэхгүй байна. Зээлийн авлагаар тайлагнах нь зүйтэй.

Шийдвэрлэсэн нь:

Аудитын зөвлөмжийн дагуу Бусад эргэлтийн бус хөрөнгө буюу урт хугацааны зээлийн авлагаар залруулж тайлагнасан.

Зээлийн хүүгийн авлагыг хуримтлуулж бүртгээгүй талаар

Дэлхийн банкны санхүүжилттэй төслийн хүрээнд авсан үндсэн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой 2013 оноос 2016 оны хооронд үүссэн 53,098.0 мянган төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг хуримтлуулан бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Аудитын зөвлөмжийн дагуу зээлийн хүүгийн авлагаар залруулж тайлагнасан.

Аудитын үйлчилгээний зардлыг 24,450.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.

Компани нь 2016 оны 3 дугаар улиралд 2016 оны аудитын үйлчилгээний төлбөр 44,090.9 мянган төгрөгийн зардлыг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч тайлагнасан. Уг өр төлбөрийн 24,250.0 мянган төгрөгийг 2016 оны 11 сард шилжүүлэхдээ өр төлбөрөөс бууруулахгүйгээр дахин зардалд бичсэн нь аудитын үйлчилгээний зардлыг 24,250.0 мянган төгрөгөөр илүү, харин өр төлбөрийн дүнг 24,250.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Уг зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2. санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх; заалт болон мөн хуулийн 9.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Асуудлын бүртгэлээр 2017 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланд залруулах зөвлөмж өгсөн.

Дээрх дурьдсан асуудлуудыг хураангуйлж, нэгтгэн харуулбал:

	Зөрчлийн утга	Дүн /төгрөг/	Залруулсан эсэх
1	Хойшлогдсон татварын өглөг 160,593,303 төгрөгөөр илүү, орлогын албан татварын зардал 240,388,954.67 болон орлогын албан татварын өглөг 400,648,257.79 төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн	400,648,257.79	залруулаагүй
2	Хувь хүнд олгосон 5,800,000 төгрөгийн орлогоос хувь хүний орлогын албан татвар болох 580,000 төгрөгийг суутгаж, төсөвт шилжүүлээгүй.	580,000.00	залруулаагүй
3	Бараа материалын шинж чанартай нийт 13,010,000 төгрөгийн бараа материалыг орлогод авалгүй, шууд зардалд бүртгэж, тайлагнасан.	13,010,000.00	залруулаагүй
4	Аудитын үйлчилгээний зардал болон өр төлбөрийг 24250,000 төгрөгөөр илүү илэрхийлсэн.	24,250,000.00	залруулаагүй
	дэд дүн	438,488,257.79	
5	Нийт 99,820,435 төгрөгийн урьдчилж төлсөн зардлыг аккрузль сууриар бүртгэлгүй шууд зардлаар бүртгэж, тайлагнасан.	99,820,435.00	залруулсан
6	ААНОАТ-ын хуулийн дагуу татвар ногдох орлогоос хасагдахгүй 2,037,518.18 төгрөгийн зардлыг татвар ногдох орлогоос хасч тайлагнасан.	2,037,518.00	залруулсан
7	Үндсэн хөрөнгийн товчоо тайлангийн дүн, санхүүгийн тайлангийн тодруулга болон гүйлгээ балансын дүнгээс 404,155,737 төгрөгөөр зөрүүтэй.	404,155,737.00	залруулсан
8	4,015,000 төгрөгийн өр төлбөрийг буруу ангилж бүртгэсэн.	4,015,000.00	залруулсан
9	693,517,765 төгрөгийнн Зээлийн авлагыг хөрөнгө оруулалтаар тайлагнасан	693,517,765.00	залруулсан
10	53,098,045 төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг хуримтлуулж бүртгээгүй	53,098,045.00	залруулсан
	дэд дүн	1,256,644,500.00	
	Нийт	1,695,132,757.79	

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитаар 4 асуудлаар нийт **438,488.3** мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа илэрсэн. Залруулагдаагүй алдааны тайлбарыг дээрх хүснэгтээс харна уу.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Өмнөх аудитын зөвлөмжөөр бараа материалын насжилт өндөр, хуучирч хоцрогдсон, цаашид ашиглах боломжгүй бараа материалын үлдэгдэл ихтэй, уг бараа материалуудыг борлуулах, акталж устгах талаар зөвлөмж өгсөн боловч тайлант хугацааны эцэст насжилт өндөртэй буюу 5 жилээс дээш насжилттай 1,052,397.2 мянган төгрөгийн үнийн дүнтэй бараа материал байсаар байна. Уг бараа материалуудыг цаашид ашиглах,

борлуулах, акталж данснаас хасах талаар авах арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн тайлангийн жилд дараах асуудалд анхаарлаа хандуулна. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн татварын зорилгоор байгуулж буй элэгдлийн тооцоолол, дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн татварын зорилгоор байгуулсан элэгдлийн тооцооллыг дахин тооцооллоор нарийвчлан шалгах
- Бараа материалын хасагдуулгын тооцооллыг салбар, нэгж бүрээр дахин тооцоолох
- Цахилгаан эрчим хүч хэрэглэгчдээс үүссэн насжилт өндөр авлагыг нарийвчилж шалгах,
- Төсөв, төлөвлөгөө бодитой хийгддэг эсэх, гүйцэтгэлд тавигдах хяналт,
- Худалдан авалт, тендер сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа
- Эрчим хүчний яамны гэрээт ажил зэрэгт анхаарлаа хандуулна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт **1,695,132.7** мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс **1,256,644.5** мянган төгрөгийн дүнтэй залруулга хийж, **438,488.2** мянган төгрөгийн зөрчилд асуудлын бүртгэл, удирдлагад хүргэх захидлаар зөвлөмж өгсөн.

Удирдлагад хүргэх захидлаар зөвлөмжөөр өгсөн дахин үнэлсэн хөрөнгөнд байгуулсан элэгдлийн зардлыг татвар ногдох орлогоос хасч тайлагнаснаас үүссэн орлогын албан татварын өглөгийн 400,648.3 мянган төгрөгийн дутуу илэрхийлэл, аудитын үйлчилгээний зардал 24,250.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн зэрэг залруулаагүй алдааны нөлөөллийн зөрчлийн дүнг санхүүгийн тайланд нөлөөлөх нөлөөллийг бага гэж үзлээ.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэлийн дэлгэрэнгүй дараах байдалтай байна. Үүнд:

- Хойшлогдсон татварын өглөг 160,259.3 мянган төгрөгөөр илүү, орлогын албан татварын 240,389.0 мянган төгрөг, орлогын албан татварын өглөг 400,648.3 мянган төгрөгийн өглөг уг дүнгээр дутуу илэрхийлэгдсэн.
- Нийт 99,820.4 мянган төгрөгийн урьдчилж төлсөн зардлыг аккрузль сууриар бүртгэлгүй шууд зардлаар бүртгэж, тайлагнасан.
- ААНОАТ-ын хуулийн дагуу татвар ногдох орлогоос хасагдахгүй 2,037.5 мянган төгрөгийн зардлыг татвар ногдох орлогоос хасч тайлагнасан.
- Үндсэн хөрөнгийн товчоо тайлангийн дүн, санхүүгийн тайлангийн тодруулга болон гүйлгээ балансын дүнгээс 404,155.7 мянган төгрөгөөр зөрүүтэй.
- Зарим үндсэн хөрөнгийн санхүүгийн зорилгоорх тооцсон элэгдлийн дүн ЭХЗ Хорооноос баталсан журамтай нийцээгүй.
- Хувь хүнд олгосон 5,800.0 мянган төгрөгийн орлогоос хувь хүний орлогын албан татвар болох 580.0 мянган төгрөгийг суутгаж, төсөвт шилжүүлээгүй.
- Бараа материалын шинж чанартай нийт 13,010.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авалгүй, шууд зардалд бүртгэж, тайлагнасан.
- 4,015.0 мянган төгрөгийн өр төлбөрийг буруу ангилж бүртгэсэн.
- 693,517.8 мянган төгрөгийнн Зээлийн авлагыг хөрөнгө оруулалтаар тайлагнасан

- 53,098.0 мянган төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг хуримтлуулж бүртгээгүй.
- Аудитын үйлчилгээний зардлыг 24,250.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Улаанбаатар аудит корпораци” ХХК нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, нийт 12 зөвлөмж өгснөөс бүгдийг хэрэгжүүлсэн байна.

Аудитын санал дүгнэлт

Бид “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2016 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн тайланд хийсэн аудитдаа үндэслэн **“Зөрчилгүй”** санал дүгнэлт өгөхийг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын даргад санал болгож байна.



**“УБЦТС” ТӨХК-ИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын САГ-ын дарга,
Тэргүүлэх аудитор:
Ц. Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 261885

Ахлах аудитор: Д.Ганбилэг
Утас: 260512

ТАБ-ын хаяг:
Үндэсний аудитын газар
Байршил: Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын IV байр
Цахим хуудас: www.audit.mn



“Улаанбаатар аудит корпораци”ХХК

Аудитын партнер : Н.Эрдэнэцог
Утас: 976-11-70110744, 99030092
И-мэйл: erdenetsog@ulaanbaatar-audit.mn

Аудитын менежер: Б. Дэлгэрмаа
Утас: 976-11-329430, 99005373
И-мэйл: delgermaa@ulaanbaatar-audit.mn

Хаяг: Чингэлтэй дүүрэг, .
5-р хороо, Их тойруу, Маргад центр байрны
4-р давхар

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Хойшлогдсон татварын өглөг

Асуудал 2
Санхүүгийн программ хангамж

2017 оны 3 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тус компанийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Хойшлогдсон татварын өглөг	Тэргүүлэх ач холбогдол №2
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Компани нь 2015 онд элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй хөрөнгийг 15,915,531.8 мянган төгрөгөөр дахин үнэлүүлсэн. Тайлант 2016 онд компани нь уг дахин үнэлүүлсэн үндсэн хөрөнгөнд нийт 1,602,593.0 мянган төгрөгийн дүнтэй татварын зорилгоор элэгдэл байгуулж, "Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан"-д тайлагнасан байна. Уг зөрүүгийн тайлангийн түр зөрүүгийн хасагдуулах утга хэсэгт дахин үнэлсэн хөрөнгийн элэгдлийг татварын зорилгоор тайлагнасан нь орлогын албан татварын өглөгийг 400,648.3 мянган төгрөгөөр, орлогын албан татварын зардлыг 240,389.0 мянган төгрөгөөр бууруулж, харин хойшлогдсон татварын өр төлбөрийг 160,259.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх нөлөө үзүүлсэн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд буруу мэдээлэл өгөх, татварын албаны хяналт шалгалтаар торгууль, алданги, нөхөн төлбөр төлөх эрсдэлтэй.

ҮАГ-ын зөвлөмж

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалт "Үндсэн хөрөнгийг дор дурдсан хугацаагаар ашиглахаар тооцож, түүний элэгдэл, хорогдлын шимтгэлийг шулуун шугамын аргаар дараахи байдлаар байгуулна. Барилга байгууламж 40 жил, машин тоног төхөөрөмж 10 жил" гэж заасан нь элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгөд татварын зорилгоор дахин элэгдэл байгуулж татвар ногдох орлогоос хасахаар заагаагүй байх тул Компани 2015 онд дахин үнэлүүлсэн үндсэн хөрөнгийн татварын зорилгоор байгуулсан элэгдлийг үнэн зөв тооцож, татварын тайланд үнэн зөв тайлагнах шаардлагатай. Аудиторын санал болгож буй бичилт нь:

Дт Хойшлогдсон татварын өр төлбөр 160,259,303.12

Дт Орлогын албан татварын зардал /хуримтлагдсан ашиг/ 240,388,954.67

Кт Орлогын албан татварын өглөг 400,648,257.79

Үйлчлүүлэгчийн хариу

Дахин үнэлсэн хөрөнгийн асуудлыг эрчим хүчний яамнаас гарах НБББББ-нд тусгуулах талаар Эрчим хүчний салбарын ТӨХК-ийн санхүүгийн ажилтнууд хэлэлцсэний үр дүнд, ЭХЯ-наас нэгдсэн шийдвэр гаргуулах талаар санал оруулсан. ЭХЯ нь холбогдох байгууллагуудтай хамтран дахин үнэлсэн хөрөнгө төдийгүй Улс, Нийслэлийн хөрөнгө оруулалтаарх үндсэн хөрөнгө, Үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийн талаар тодорхой чиглэл өгөхөөр болсон ч одоогоор гарсан шийдвэр байхгүй байна. УБЦТС ТӨХК-ийн Санхүү бүртгэлийн хэлтэс нь 2017 оны ажлын төлөвлөгөөнд үндсэн хөрөнгийн бүртгэл, тооцооллыг нэгдсэн журамд оруулах талаар ажлын хэсэг байгуулан ажиллахын тулд үндсэн хөрөнгийн нягтлан бодогчийн орон тоог нэмэгдүүлэн ажиллаж байна.

Асуудал 2: Санхүүгийн програм хангамж	Тэргүүлэх ач холбогдол №2
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Компанийн санхүүгийн Даймонд программ нь элэгдлээрээ өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн татварын элэгдлийг бусад элэгдэл тооцох үндсэн хөрөнгийн татварын зорилгоорх элэгдлээс ялгаж тооцох боломжгүй байна. Энэ нь дахин үнэлсэн, татварын зорилгоор элэгдэл байгуулахгүй үндсэн хөрөнгөнд татвар тооцож тайлагнаснаас компанийн хойшлогдсон татварын өглөг болон орлогын албан татварын өглөгийн тооцоололд хүндрэл учруулж байна. Түүнчлэн үндсэн хөрөнгийн гүйлгээ балансын дүн нь үндсэн хөрөнгийн товчоо тайлангийн дүнгээс зөрүүтэй тайлагнагдах зөрчил гарч байна. татварын зорилгоорх элэгдлийг үндсэн хөрөнгийн гүйлгээ баланс болон үндсэн хөрөнгийн товчоо тайлан зөрүүтэй тайлагнадаг байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан хэрэглэгчдэд буруу ташаа мэдээлэл өгөх,

ҮАГ-ын зөвлөмж

Санхүүгийн программ үйлчилгээ эрхэлсэн компаниас дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн татварын зорилгоорх элэгдлийн тооцооллыг бусад үндсэн хөрөнгийн татварын зорилгоорх элэгдлийн тооцооллоос тусад нь тооцоолж, тайлагнах үйлчилгээ авах.

Үйлчлүүлэгчийн хариу

“Интерактив Би Ай” ХХК-д албан бичгээр асуудлыг шаардсан боловч тус компанийн зүгээс бидний хэрэглэж буй Даймонд-5 програмд ямар нэгэн шинэчлэлт хийгдэхгүй тул Даймонд-6 програмыг санал болгосон.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

“УБЦТС” ТӨХК

2016 оны 12 сарын 31-ний байдлаар
(Төгрөгөөр)

	Тодруулга	2016	2015
ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	2,843,632,147.17	1,008,201,872.14
Дансны авлага	4	20,214,112,562.62	17,470,606,043.77
Татвар, НДШ-ийн авлага	5	428,696,021.47	751,652,169.75
Бусад авлага	6	631,186,308.52	462,514,852.81
Бараа материал	7	5,782,038,618.00	6,426,306,897.73
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8	1,115,273,491.38	1,393,929,563.72
Бусад эргэлтийн хөрөнгө	9	-	31,000,000.00
Эргэлтийн хөрөнгийн дүн		31,014,939,149.16	27,544,211,399.92
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	10	178,390,205,046.85	149,890,118,436.24
Биет бус хөрөнгө	11	1,098,331,383.28	458,999,058.05
Бусад эргэлтийн хөрөнгө	12	8,102,550,822.53	8,715,828,846.28
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		187,591,087,252.66	159,064,946,340.57
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		218,606,026,401.82	186,609,157,740.49
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	13	6,383,827,133.69	7,678,318,816.85
Татварын өр	14	1,594,043,367.06	13,346,369.67
НДШ-ийн өглөг	14	858,755.53	-
Хүүний өглөг	15	0.02	71,046,357.03
Урьдчилж орсон орлого	16	2,319,758,198.89	2,834,933,783.16
Бусад богино хугацаат өр төлбөр	17	2,124,753,424.10	1,223,688,937.47
Богино хугацаат өр төлбөрийн дүн		12,423,240,879.29	11,821,334,264.18
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	18	40,288,982,771.57	41,523,370,784.20
Хойшлогдсон татварын өр	19	1,884,510,770.96	1,289,016,463.85
Бусад урт хугацаат өр төлбөр	18	3,586,574,562.90	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		45,760,068,105.43	42,812,387,248.05
Өр төлбөрийн нийт дүн		58,183,308,984.72	54,633,721,512.23
Эздийн өмч			
- Төрийн	20	80,764,538,429.43	19,082,608,460.40
- Хувийн өмч		-	-
- Хувьцаат өр төлбөр		-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20	50,416,130,722.15	50,774,386,305.42
Эздийн өмчийн бусад хэсэг	20	20,981,223,410.32	61,169,019,629.03
Хуримтлагдсан ашиг,(алдагдал)	20	8,260,824,855.20	949,421,833.41
Эздийн өмчийн дүн		160,422,717,417.10	131,975,436,228.26
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		218,606,026,401.82	186,609,157,740.49

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

“УБЦТС” ТӨХК

2016 оны 12 сарын 31-ний байдлаар

(Төгрөгөөр)

	Тодруулга	2016	2015
Борлуулалтын орлого (цэвэр)	21	281,671,097,958.87	255,299,379,140.54
Борлуулалтын өртөг	22	(241,568,427,385.99)	(228,461,097,367.95)
Нийт ашиг (алдагдал)		40,102,670,572.88	26,838,281,772.59
Түрээсийн орлого	23	22,589,636.34	37,765,454.56
Хүүгийн орлого	23	77,165,780.72	36,220,437.14
Бусад орлого	24	6,493,349,623.26	7,330,551,646.18
Борлуулалт, маркетингийн зардал	25	(22,962,041,091.51)	(19,605,852,995.12)
Ерөнхий ба удирдлагын зардал	26	(8,677,571,515.54)	(7,979,200,801.74)
Санхүүгийн зардал	27	(657,668,686.16)	(152,811,886.08)
Бусад зардал	28	(7,252,884,331.54)	(5,860,792,606.89)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	29	82,328.22	165,995.43
Бусад ашиг (алдагдал)		-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		7,145,692,316.67	644,327,016.07
Орлогын татварын зардал	30	(1,611,498,831.75)	(90,702,684.24)
Татварын дараах ашиг (алдагдал)		5,534,193,484.92	553,624,331.83
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал		5,534,193,484.92	553,624,331.83
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-	-
Бусад олз (гарз)		-	-
Орлогын нийт дүн		5,534,193,484.92	553,624,331.83

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

“УБЦТС” ТӨХК

2016 оны 12 сарын 31-ний байдлаар

(Төгрөгөөр)

	Энгийн хувьцаа	Хөрөнгийн үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Дүн
2014 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,125,300,000.00	35,148,428,090.35	29,562,654,844.38	329,829,662.69	69,166,212,597.42
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	65,967,838.89	65,967,838.89
Өмчид гарсан өөрчлөлт	14,957,308,460.40	-	31,606,364,781.65	-	46,563,673,242.05
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	15,625,958,215.07	-	-	15,625,958,215.07
Тайлант үеийн цэвэр ашиг, (алдагдал)	-	-	-	553,624,331.83	553,624,331.83
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	19,082,608,460.40	50,774,386,305.42	61,169,019,629.03	949,421,833.41	131,975,436,228.26
Өмчид гарсан өөрчлөлт	61,681,929,969.03	-	(40,187,796,218.71)	1,308,229,087.23	22,802,362,837.55
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(358,255,583.27)	-	358,255,583.27	-
Тайлант үеийн цэвэр ашиг, (алдагдал)	-	-	-	5,534,193,484.92	5,534,193,484.92
Зарласан ногдол ашиг	-	-	-	110,724,866.37	110,724,866.37
2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	80,764,538,429.43	50,416,130,722.15	20,981,223,410.32	8,260,824,855.20	160,422,717,417.10

Нэмэлт тодрууллагууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

“УБЦТС” ТӨХК

2016 оны 12 сарын 31-ний байдлаар

(Төгрөгөөр)

	2016	2015
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	681,147,639,699.31	332,010,180,329.51
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	290,796,054,446.37	262,036,390,506.68
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	324,318,354.00	329,945,450.00
Буцаан авсан албан татвар	371,564.00	1,636,095.00
Бусад мөнгөн орлого	390,026,895,334.94	69,642,208,277.83
Мөнгөн зарлагын дүн (-)	(667,330,740,145.23)	(328,381,728,861.40)
Ажилчидад төлсөн	(5,919,037,222.02)	(21,789,585,251.43)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(1,581,406,314.37)	(6,257,359,160.91)
Бараа материал худалдан авхад төлсөн	(4,601,947,985.57)	(7,999,915,046.44)
Ашиглалтын зардалд төлсөн	(662,292,089.46)	(599,221,993.51)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(1,255,542,742.11)	(1,285,389,154.49)
Хүүний төлбөрт төлсөн	(16,000,000.00)	(60,328,269.95)
Татварын байгууллагад төлсөн	(5,965,086,847.35)	(7,818,614,485.62)
Даатгалын төлбөрт төлсөн	(42,643,556.24)	(197,964,456.34)
Бусад мөнгөн зарлага	(647,286,783,388.11)	(282,373,351,042.71)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,816,899,554.08	3,628,451,468.11
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	77,165,780.72	36,219,369.10
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хүлээн авсан хүүний орлого	77,165,780.72	36,219,369.10
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	(12,089,717,387.99)	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(12,089,717,387.99)	(3,663,481,181.73)

	2016	2015
Биет бус хөрөнө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(12,012,551,607.27)	36,219,369.10
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	31,106,532.90	380,964.82
Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө	-	-
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	31,000,000.00	-
Төрөл бүрийн хандив	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	106,532.90	380,964.82
Мөнгөн зарлагын дүн (-)	(24,204.68)	(3,000,214,969.39)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	(3,000,000,000.00)
Санхүүгийн түрээсийн төлбөрт төлсөн	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(24,204.68)	(214,969.39)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	31,082,328.22	(2,999,834,004.57)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,835,430,275.03	664,836,832.64
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,008,201,872.14	343,365,039.50
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,843,632,147.17	1,008,201,872.14